

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР
 ЭРХ ЗҮЙН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР 2018 ОНД
 ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2018.12.10

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн	Биелэлт
1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Агентлагийн даргын тушаал шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах	Тухай бүр	Бодлого төлөвлөлтийн хэлтэс	Тогтоол шийдвэр, эрх зүйн баримт бичгүүдийн холбогдох заалтын биелэлтийг хангах ажлыг чанартай зохион байгуулсан байна.	<p>Хууль тогтоомж, салбарын бодлого шийдвэр, байгууллагын даргын тушаал, байгууллагын үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тогтоол шийдвэр, эрх зүйн баримт бичгүүдийн холбогдох заалтыг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, ХХҮЕГ-ын даргын 2017 оны А/105 дугаар тушаалын дагуу тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагуудад тайлагнан ажиллаж байна. Зохион байгуулсан ажлаас дурьдвал:</p> <p>1.Тайлант хугацаанд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг нийслэлийн хэмжээнд 2018.04.01–2018.05.01-ний хооронд “Ажлын байран дахь ХАБЭА-н соёлыг төлөвшүүлэхэд Залуучуудын оролцоог нэмэгдүүлцгээе” уриан дор зохион байгууллаа.</p> <p>2.Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг нэг дороос үзүүлэн нэг талаас ажил хайгч иргэдэд түр болон байнгын ажлын байраар хангагдах боломж нөхцөлийг бүрдүүлэх, нөгөө талаас ажил олгогчид шаардлагатай ажиллах хүчнээр хангагдахад дэмжлэг үзүүлэх, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Нийслэлийн Засаг</p>

				<p>даргын Тамгын газар, Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, “Эйч ар клуб” ТББ хамтран “Нэг өрх-Нэг ажлын байр” хөдөлмөрийн яармаг, “Хөдөлмөрийн нэгдсэн өдөрлөг”-ийг 2018 оны 09 дүгээр сарын 19,20-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд зохион байгууллаа.</p> <p>3.Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, “Нэг өрх-Нэг ажлын байр” дэд хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд дэвшүүлсэн хөдөлмөрийн зах зээлийн зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тодорхой зорилтуудыг хангах хүрээнд залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар хамтран "Хөдөлмөрч залуучууд" хөдөлмөрийн яармагийг 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд зохион байгууллаа.</p> <p>4. Нийгмийн олон талын оролцоонд тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх боломж, гарц, шийдлийг тодорхойлох, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, техник технологийн болон менежментийн өөрчлөлт, шинэчлэл хийх шаардлага, түүнийг хэрэгжүүлэх арга замын талаар</p>
--	--	--	--	---

					хэлэлцэх зорилгоор Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газраас санаачлан Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Карьер хөгжлийн төвтэй хамтран “Хөдөлмөр эрхлэлтийн форум-2018” арга хэмжээг “Нэг өрх-Нэг ажлын байр” уриан дор 2018 оны 12 дугаар сарын 04-ны өдөр хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван тал, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, боловсрол, шинжлэх ухааны салбарын төрийн болон төрийн бус байгууллагууд, ажил олгогч аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоод, эрдэмтэн судлаачид зэрэг 300 гаруй төлөөллийг оролцуулан зохион байгууллаа.
2	“Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн Газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангаж тайлагнах	Тухай бүр	Бодлого төлөвлөлтийн хэлтэс	Албан даалгавраар өгсөн үүргийн дагуу сар бүр тодорхой ажил зохион байгуулсан, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Засгийн Газрын “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2017 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус байгууллагаас 3 зорилт, 16 үйл ажиллагаа бүхий ажлын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг ханган, сар бүрийн 05, 20-ны дотор ХХҮЕГ, Нийслэлийн ЗДТГ-т тайлагнан ажиллаж байна. Мөн албан даалгаврын хүрээнд сар бүр тодорхой ажлууд зохион байгуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан төрийн албан хаагчдын ёс зүй, ажлын цаг ашиглалт, бүтээмжид дотоод хяналт, үнэлгээ хийн, зөвлөмж, дүгнэлт гарган ажиллалаа.
3	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хууль тогтоомж, стандартын дагуу тогтмол хийх, хяналт шалгалтаар өгсөн зөвлөмж, дүгнэлтийн гүйцэтгэх	Тухай бүр	Бодлого төлөвлөлтийн хэлтэс	Байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилгоор дотоод хяналтыг сайжруулж, гарсан дүгнэлт,	Тус байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний нэгж салбарын хэмжээнд мөрдөгдөж буй бодлогын болон захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавин, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад дотоод

	ажлын төлөвлөгөө боловсруулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах			зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан байна.	хяналт, мониторингийн ажлыг чиглүүлэн ажиллав. Засгийн Газрын 2011 оны 311-р тогтоолын дагуу газрын даргын 2017 оны А/16 дугаар тушаалаар Дотоод хяналтын журмыг батлан мөрдөн ажиллаж байна. Мөн хяналт-шинжилгээ, дотоод мониторингийн жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус байгууллагаас 450 албан бичиг, дүрэм журам, төлөвлөгөө, тайлан боловсруулан бүртгэж холбогдох байгууллага, аж ахуй нэгжид хүргүүлээд байна.
4	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай хүргэх	Тухай бүр	Бодлого төлөвлөлтийн хэлтэс	Байгууллагын үйл ажиллагааны, хүний нөөцийн, санхүү төсвийн, худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдал хангагдсан байна.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хүрээнд Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2012 оны А/606 дугаар захирамжийн дагуу байгууллагын цахим сайт, мэдээллийн самбарт байгууллагын үйл ажиллагааны, хүний нөөцийн, санхүү төсөв, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт зэрэг мэдээллийг нээлттэй, ил тод байршуулан ажиллалаа. Газрын үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээлэл, сурталчилгаа /шторк/-г Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын www.ubbirj.ub.gov.mn цахим сайт, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв фэйсбүүк хуудсуудаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчилсан. НЗДТГ-ын хэвлэл мэдээллийн албатай хамтран телевиз, радиогоор зохион байгуулсан арга хэмжээ, ажлын байрны

				<p>өдөрлөгүүдийн талаарх мэдээ, мэдээллийг тухай бүр хүргэн, иргэд олон нийтэд сурталчлан ажиллав.</p> <p>Шилэн дансны хуулийн хэрэгжилт, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 11 дүгээр хавсралтаар баталсан “Ил тод байдлын шалгуур үзүүлэлт”-ийг хангаж, байгууллагын ubbirj.ub.gov.mn болон shilendans.gov.mn сайтад 27 төрлийн мэдээллийг хууль журманд заасан хугацааны дотор оруулж хэвшээд байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/43 дугаар захирамжийн дагуу төсвийн сахилга, хариуцлагыг чангатгаж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулж байна.</p> <p>Энэ онд тус газраас 165,7 сая төгрөгийн өртөг бүхий Үрийн төмс, хожуу тариалалтын навчит болон булцуут ногооны үр худалдан авах, хүнсний ногоо тариалах хураахтай холбогдуулан үрлэгч, капатал тус бүр 2-ыг, 18 ширхэг хүлэмж худалдан авах тухай 5 тендерийг цахимаар зохион байгууллаа.</p> <p>Мөн Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1037 дугаар захирамжийн дагуу Хөдөлгөөнт биржийн албан хэрэгцээнд шаардлагатай байгаа автомашин нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог НХЭГ-ын даргын 2018 оны А/49 дүгээр тушаалаар байгуулж, үнэлгээний хороо холбогдох журмын</p>
--	--	--	--	--

					дагуу тендерийн баримт бичгийг боловсруулан www.tender.gov.mn сайт байршуулан, нээлттэй тендерийг зарлаад байна.
5	Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, мэдээллийг баяжуулж, цахим сан бүрдүүлэх, мэргэжил арга зүйн заавар чиглэл өгч, хамтран ажиллах	Тухай бүр	Бодлого төлөвлөлтийн хэлтэс	Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа нь холбогдох хууль, дүрэм журам, стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.	Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган “Цахим архив” төслийн хүрээнд Нийслэлийн Архивын газраас нэвтрүүлсэн албан хэрэг хөтлөлтийн “e-doc”, архивын “Archive e-doc”, erp.ulaanbaatar.mn , программуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж хэвшээд байна. Дээрх программуудыг ашигласнаар баримт материалыг бүртгэх, архивын сан хөмрөгт орсон өөрчлөлт, хөдөлгөөн болон нэгдсэн мэдээ тайланг үнэн зөв хөтлөн явуулах, баримтын хадгалалт, хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүлсэн. Захирамжлалын баримт бичиг болох Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын даргын А, Б archive edoc програмд бүрэн оруулж, нягтлан шалгах ажлыг хийж гүйцэтгэсэн.
6	Ажилтан, албан хаагчдыг 2018 онд чадавхижуулах сургалтын хүрээнд төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангах, үр дүнд хяналт тавих		Бодлого төлөвлөлтийн хэлтэс	Албан хаагчдад төрийн албаны стандарт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ажлын байранд мөрдөх хэм хэмжээний журам, ёс зүйн хэм хэмжээний талаар болон бусад мөрдөх журам, дүрмийн талаар сургалт зохион байгуулж, ажлын хариуцлагыг дээшлүүлэхэд	“Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох” хөтөлбөрийн хүрээнд байгууллагын ажилтан, албан хаагчдыг чадавхижуулах 2018 оны сургалтын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийн, холбогдох дээд шатны байгууллагад тайлагнан ажиллалаа. Үүнд: 1.Холбогдох дээд газар болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан 24

				хяналт тавьж ажилласан байна.	төрлийн сургалтад 45 албан хаагч давхардсан тоогоор 110 цагийн сургалт 2. Байгууллага дотооддоо 8 төрлийн давхардсан тоогоор 252 цагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 101 албан хаагчийг хамруулсан. 3. Гадаад улс оронд зохион байгуулагдсан 3 удаагийн сургалт, туршлага солилцох уулзалтад 3 албан тушаалтан хамрагдсан байна. Нийт 34 нэр төрлийн давхардсан тоогоор 402 цагийн сургалтад 247 албан хаагчийг хамруулж чадавхижуулан, мэдлэг ур чадварыг дээшлүүлсэн байна.
7	Байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг тогтмол, үр дүнтэй зохион байгуулах	Тухай бүр	Бодлого төлөвлөлтийн хэлтэс	Байгууллага болон салбарын үйл ажиллагааг сурталчлах, салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэрийг танилцуулах, мэдээлэх ажлыг оновчтой арга хэлбэрээр зохион байгуулсан байна.	Байгууллагын үйл ажиллагааны болон шилэн дансны мэдээлэл, авилгын эсрэг үйл ажиллагаа, би хариуцлагатай аав, ээж зэрэг мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулан, салбарын хууль тогтоомж, дүрэм, журам, цаг үеийн мэдээ мэдээлэл, тайлан зэргээр тогтмол баяжуулан ажиллаж байна. Байгууллагын ubbiri.ub.gov.mn цахим хуудсанд үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж байна. Мөн тус байгууллага, салбарын үйл ажиллагааг сурталчлах, оновчтой арга хэлбэрээр зохион байгуулах үүднээс “Энх-Арслан”, “Супер сольюшнс” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.
8	Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дугаар тогтоолын дагуу албан хаагчдын Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах	Тухай бүр	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж , дүрэм журмын хэрэгжилт сайжирсан байна.	Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын даргын 2018 оны А/01 дүгээр тушаалаар албан хаагчдын ажлын байрны жагсаалт шинэчлэн батлагдсантай холбогдуулан Ажлын байр

					<p>/албан тушаал/-ын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулсан.</p> <p>Мөн Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын албан хаагчдын ажлын байранд дүн шинжилгээ хийх ажлын хэсгийг газрын даргын 2018 оны А/37 дугаар тушаалаар байгуулж, ажлын байрны шинжилгээнд Газрын дарга-1 /ТЗ-10/, хэлтсийн дарга-3 /ТЗ-8/, төрийн захиргааны албан хаагч-14 /ТЗ-5, ТЗ-6/, төрийн үйлчилгээний албан хаагч-2 /ТҮ-6, ТҮ-7/ нийт 20 ажилтан, албан хаагч хамрагдсан.</p> <p>Ажлын байрны шинжилгээг цуглуулахдаа Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, эрх зүйн актуудыг тус тус удирдлага болгон батлагдсан загвар маягтын дагуу нэгдсэн удирдамжид тусгагдсан асуудлын дагуу ажлын байрны шинжилгээг хийж гүйцэтгэн ажлын хэсэг байгууллагын удирдлагад хийсэн ажлын талаар товч мэдээллийг танилцуулсан.</p> <p>Зарим албан тушаалын нэршил нь ижил байгаагийн учир шалтгаан нь ажиллах орчны байршил, албан тушаалын ажлын чиг үүрэг өөр байгаатай холбоотой байна.</p>
9	Газрын хэмжээнд гарч буй гэрээний эрх зүйн актуудын хууль зүйн үндэслэлийг хянаж, хууль эрхийн актад нийцүүлэх	Тухай бүр	Бодлого төлөвлөлтийн хэлтэс	Гэрээний эрх зүйн актуудын хууль зүйн үндэслэл нь хууль эрхийн актад нийцэж хохирол учраагүй байх.	Тайлант хугацаанд газрын хэмжээнд 281 гэрээ гарсан бөгөөд гэрээний хууль эрх зүйн үндэслэлийг эрх зүй, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн хянаж нэгдсэн дугаар олгож байна.
10	Төрийн албан хаагчдад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, ХАСХОМ-ийг мэдүүлэг гаргагчаас	Тухай бүр	ЭБАТ	Мэдүүлгийн тайлан, мэдээг бүртгэлийн маягтын дагуу хөтөлж хуулийн хугацаанд хүргэсэн байна.	УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төлөвлөгөө гаргаж батлуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг НЗДТГ-ын

	хуулийн хугацаанд үнэн зөв хүлээн авч, нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг АТГ-д хүргүүлж хянуулах				<p>Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүллээ. Мөн Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Авилгатай тэмцэх газрын олон нийтийн төвд зохион байгуулагдсан Авилгын эсрэг сургалтуудад 22 албан хаагч хуваарийн дагуу оролцлоо.</p> <p>2 албан тушаалтан ХАСХОМ-г хуулийн хугацаанд гаргаж, байгууллагын ЭБАТ хянан баталгаажуулж, холбогдох тайланг ХХҮЕГ-т хүргүүлсэн. Мөн нийтийн албанд томилогдхоор нэр дэвшсэн С.Нямдорж, С.Нарантуяа, Д.Баясгалан нарын ХАСУМ-ыг АТГ-т хүргүүлж, тус газрын 2018 оны 05/1551, 05/1275, 05/4327 тоот албан бичгийг тус тус үндэслэн газрын даргын тушаалаар дээрх нэр бүхий этгээдүүдийг тухай албан тушаалд томиллоо.</p>
11	Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж дүрэм журмыг аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлах	Тухай бүр	Хэлтсүүд	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирсан байна.	<p>ХНХ-ын Сайдын 2018.02.05-ны өдрийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамжид орох нэмэлт өөрчлөлтийг батлах тухай А/19 дүгээр тушаалын дагуу ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй иргэдэд ганцаарчилсан болон, бүлгээр мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж байна.</p> <p>Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар нь хөтөлбөрийн үндсэн зорилтын хүрээнд иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг нэг дороос үзүүлэх “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг байгуулан</p>

					<p>2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Дүнжингарав салбарт нээлтийн арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Тус төв нь ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагуудаас ажлын байрны захиалга авах, ажил хайгч иргэнийг бүртгэх, ажилд зуучлах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллээр хангах, сургалт, арга хэмжээ, төсөл хөтөлбөрт хамруулах зэрэг үйлчилгээг нэг дороос үзүүлж, залуучууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, албан бус эдийн засгийн салбарт хөдөлмөр эрхлэгчдийг дэмжин ажиллах, холбогдох стандарт, шаардлагад нийцсэн үйлчилгээний таатай орчныг бүрдүүлснээрээ онцлог юм.</p>
--	--	--	--	--	--